

Төмөр хонин жил нь гахай болон туулай жилтэй хүмүүсийн хувьд аливаа ажил үйлсээ бүтээхэд хамгийн тохиромжтой жил тул тэдгээр хүмүүс энэ боломжийг сайтар ашиглах хэрэгтэй. Харин үхэр жилтэнгүүдийн хувьд аливаа ажил үйлсийг явуулахдаа урдаас илүү хянуур болгоомжтой хандах нь зүйтэй. Чингэвээс таны үйлс санасанчлан бүтмүй.

Хулгана жилтний хувьд элдэв найр хурим хийх аваас хаврын адаг, намрын тэргүүн сарууд онцгой тохиромжтой. Харин зуны дунд сард хянуур болгоомжтой байх нь зүйтэй. Энэ үед элдэв найр хурим хийхээс татгалзвал ашигтай байж болно. Хулгана жилтний хувьд их ажил хэргийг бүтээхээр эхлээ гэвээс 3, 4 гариг, 19, 5, 2 одтой өдрүүдийг сонгон аваарай.

Үхэр жилтний хувьд элдэв найр хурим, баяр цэнгээнийг хийх аваас зуны тэргүүн, намрын дунд саруудад ихэд тохиромжтой. Зуны адаг сард аливаа ажил үйлсийг хийж бүтээхдээ хянуур нямбай байхаас гадна хурим найрыг хийхээс аль болохоор татгалзвал ашигтай. Ашигтай ажил үйлсийг эхлэн бүтээхдээ 0, 4 гариг, 16, 13, 11 одтой өдрүүдийг сонговол сайн.

Бар жилтний хувьд холын аян замд явж жуулчлах, найр хурим хийх, баяр цэнгээнийг үүсгэх аваас зуны дунд, намрын адаг саруудыг сонгоорой. Намрын тэргүүн сард аливаа ажил үйлсийг хийхдээ хянуур нямбай байвал ашигтай. Чухал хэрэг үйлсийг бүтээхдээ 5, 0 гариг болон 4, 26, 8 одтой өдрүүдийг эрхэмлээрэй.

Туулай жилтний хувьд аливаа сэтгэл хөдөлгөсөн тэмдэглэлт үйл явдлыг хийхдээ зуны адаг, өвлийн тэргүүн саруудыг эрхэмлээрэй. Намрын дунд сард аливаа ажил үйлсийг үүсгэхдээ болгоомжлох хэрэгтэй. Өөрт тустай ажил үйлсийг 5, 0 гариг, 10, 26, 11 одтой өдөр хийвэл сайн.

Луу жилтний хувьд элдэв найр хурим хийх, аливаа ажлыг цоо шинээр эхлэхийг намрын дунд, өвлийн адаг саруудад тэвчвээс зохилтой. Харин нохой сард аливаа зүйлээс болгоомжилвол сайн. Маш чухал ажил үйлсийг үүсгэхдээ 1, 4 гариг, 2, 23, 16 одтой өдрийг эрхэмлэвэл сайн ажгуу.

Могой жилтний хувьд ивээлтэй сайн сарууд нь намрын дунд, өвлийн адаг сарууд болой. Харин өвийн тэргүүн сард аливаа сайн үйлийг эхлэхээс болгоомжлох хэрэгтэй. Могойтой хүмүүс 3, 6 гариг болон 12, 11, 5 одтой өдрүүдэд эрхэм сайн үйлсээ эхлэвэл зохистой.

Морь жилтний хувьд хурим найр, баяр хөгжөөнийг үүсгэхдээ намрын адаг болон хаврын тэргүүн сарыг эрхэмлэвэл сайн. Харин өвлийн дунд сар болгоомжтой явах нь зохистой. Морь жилтэнгүүд 3, 6 гариг болон 16, 11, 5 одтой өдрүүдэд эрхэм сайн үйлээ эхлэвэл бүтэмжтэй сайн болно.

Хонь жилтний тухайд өвлийн тэргүүн, хаврын дунд саруудад найр хурим хийх, наадам зугаа үүсгэх болон буяны сайн үйлд хичээвэл нэн зохимжтой амой. Харин өвлийн адаг сард элдэв үйлс бүтээхдээ бол-

гоомжлоход илүүдэх юун. Хонь жилтний хувьд 6, 2 гариг болон 7, 9, 1 одтой өдөр ивээлтэй сайн тул элдэв үйл бүтэх нь сайн.

Бич жилтний хувьд өвлийн дунд, хаврын адаг саруудад найр хурим хийх, эрхэм сайн үйлсийг бүтээхэд зохимжтой болой. Хаврын тэргүүн сард болгоомжтой явбал зохимжтой болно. Ийм жилтний тухайд 6, 5 гариг болон 7, 0, 1 одтой өдөр эрхэм сайн тул элдэв үйлсийг бүтээ хэд зохимжтой болой.

Тахиа жилтний хувьд өвлийн адаг, зуны тэргүүн саруудад өлзийтэй сайн үйлсийг бүтээвэл нэн тохиромжтой. Харин хаврын дунд сард аливаа ажил үйлийг бүтээхдээ болгоомжтой байх хэрэгтэй. Энэ жилтэй хүмүүсийн тухайд 6, 5 гариг болон 13, 6, 24 одтой өдөр эрхэм сайн үйлээ бүтээхэд сайн.

Нохой жилтний тухайд хаврын тэргүүн, зуны дунд саруудад найр хурим, эрхэм чухал ажлыг үүсгэхэд сайн. Харин хаврын адаг сард хянуур болгоомжтой байх нь зүйтэй. Энэ жилтний хувьд 2, 4 гариг болон 8, 26, 4 одтой өдрүүд өлзийтэй сайн үйлийг бүтээхэд эрхэм сайн болно.

Гахай жилтний тухайд хурим найр хийх, өлзийтэй сайн үйлийн эхийг тавих, ажлыг төгс дуусгах зэрэгт хаврын дунд, зуны адаг саруудад эрхэм сайн. Харин зуны тэргүүн сард хянуур, нямбай явбал сайн. 4, 3 гариг болон 1, 7, 10 одтой өдөр үйл бүтээхэд эрхэм сайн.

Жич: Зурхайн ухаанд гариг одыг тоогоор тэмдэглэсэн байдаг бөгөөд хэрхэн тэмдэглэснийг хойно сийрүүлбэл, оддын тухайд Брани (1), гирдиг (2), ровагини (3), мэргшир (4), артир (5), бурнава (6), бүс (7), аспис (8), Мэг (9), бурвабэлгүни (10), удирабэлгүни (11), хасда (12), зэдра (13), сувади (14), шошаг (15), анурад (16), цэсда (17), мол (18), бурвасад (19), удирасад (20), абици (21), щирван (21), данисда (22), садабис, (23). бурвабадирабад (24), удирабадирабад (25), ривади (26), ашувани (0) бөгөөд гаригуудын хувьд адьяа (1), сумьяа (2), ан гараг (3), буд (4), бархасбадь (5), сугар (6), санчир (0) гэсэн тэмдэглэгээтэй болой.

Эдгээр од гаригуудыг шороо, ус, хий, гал, мод хэмээх язгуур дөрвөн махбодод хуваагаад тухайн өдрийн гариг болон саран хэрэхуй (цаг тооллын бичигт тэмдэглэсэн байдаг) од хоёрыг хооронд нь тохиолдуулж барилдлага хэмээх арван тохиолыг гарган авч аливаа ажил үйлсийг хөтлөн явуулахдаа тэдгээр тохиолуудыг ашигласаар иржээ. Орд, гаригийн махбодыг хүснэгтээр үзүүлбэл:

гариг	0,6	2,4	1,3	5
махбода	шороо	ус	гал	хий
од	3	5	1	0
	16	8	2	4
	17	18	7	6
	20	19	9	11
	21	22	10	12
	21	25	15	13
	23	26	24	14

Тухайн өдрийн гариг болон од (саран хэрж буй од) хоёрыг хэрэлдүүлэн тоолоход хоёр гал учирвал арвидах болох, хоёр шороо учирвал шидийн, хоёр хий учирвал хотол чуулганы, хоёр ус учирвал рашааны, гал хий учирвал хүчин төгсөх, шороо ус учирвал идэр, гал, ус учирвал

үхэх, шороо, гал учирвал түлэхийн, шороо хий учирвал үл тохирохын, ус, хий учирвал үл зохиолдохын барилдлага гэж нэрлэнэ.

Эдгээрийн арвидах болох, шид, хотод чуулган, рашаан, хүчин төгсөх, идэрийн барилдлагуудыг зургаан сайн, үхэх, түлэх, үл тохирох, үл зохилдохын барилдлагуудыг дөрвөн муу барилдлага гэж үзэн, сайн барилдлагуудад аливаа ажил үйлсэд шамдан, харин муу барилдлагуудад ажил үйлс аливаа нэгнийг явуулахдаа хянуур, нямбай болгоомжтой харьцдаг байжээ.

Тухайн өдрийн барилдлагыг мэдэхийг хүсвэл тэр өдрийн гариг болон саран одны (саран хэрэх одон энэ нь цаг тооны бичиг дээр бичээс эй буй) махбодыг олж хооронд нь хэрэлдүүлэн ямар барилдлагатай болохыг олно. Тухайлбал: Тухайн өдрийг гариг нь даваа (2), од нь ровагини (3) байвал дээрх хүснэгтээс харвал шороо, ус учирсан тул Идэрийн барилдлагатай болно.

Арван барилдлагын сайн муугийн үрийг хойно сийрүүлбэл:

1. Шидийн барилдлагатай өдөр аливаа санасан үйлс сэтгэлчлэн бутмуй. Шүтээн босгох, хот балгадыг барих, тариа тарих, худалдаа наймаа хийх зэрэг дэлгэрүүлэх үйлд сайн. Бүтээл туурвил үйлдэх зэрэг батжуулах үйлд сайн.

2. Рашааны барилдлагатай өдөр насны титмийг арвижуулах, эмийг найруулах, усан засал, угаал үйлдэх, бэр авах, насны авшиг, насан бүтээлийн зан үйл хийлгэх, төрөл садан бололцох, худалдаа наймааг үүсгэх зэрэг дэлгэрүүлэх үйлс бүхэнд сайн.

3. Идэрийн барилдлагатай өдөр сайн үйлсийг үүсгэх, баясгалангийн хурим үйлдэх, ялангуяа гэр бүл бололцох, газар хагалж тариа тарих, шинэ хувцас өмсөх, чимэг зүүх, бүжиг наадам үйлдэх зэрэгт сайн.

4. Арвидах болохын барилдлагатай өдөр идээ, хувцас олох, худалдаа наймаа үйлдэх, өглөг өгөх, хөрөнгө цацах, эдийн тэнгэрийг тахиж хийгээд шид бүтээлийг үүсгэхэд сайн.

5. Хотол чуулганы барилдлагатай өдөр санасан хэрэг түргэн бүтнэ. Хэл амыг намдаах, арга эвийг олох түргэн үйлд сайн.

6. Хүчин төгсөхийн барилдлагатай өдөр өлзийтэй буяны үйлийг үйлдэх, номын үйлийг эхлэх, гүйцээх, сүм, дуганыг нээх, амирлангуй, дэлгэрэнгүй, эрхшээх, үйл бүхэнд сайн.

7. Түлэхийн барилдлагатай өдөр элдэв сайн үйлийг эхлэн үүсгэхийг тэвчвэл сайн. Хатуу үйлийг үүсгэвэл зохистой.

8. Үл тохирохын барилдлагатай өдөр хулгай дээрмийг дарах, дайсныг номхотгох зэрэг үйлд сайн. Амраг садан бололцох, багш шавьд барилдахыг тэвч.

9. Үхэхийн барилдлагатай өдөр мал, адгуусыг муулах үйлд сайн.

10. Үл зохилдохын барилдлагатай өдөр андгай тангарагаас няцах, дайсныг номхоруулах үйл нугуудад сайн. Энэ барилдлагатай өдөр аливаа үйлийг бүтээхдээ болгоомжтой, хянуур байх нь чухаг.